



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 14 өдөр

Дугаар А/257

Хэрлэн сум

“Аймгийн заан” цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 97 жилийн ой, Хан Хэнтий Уулын аймаг байгуулагдсаны 95 жилийн ойн баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд долоо даван үзүүрлэсэн Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын харьяат Батбаярын Мандалбатад “Аймгийн заан” цол олгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА